



ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ СОНИРХОГЧ
ЭТГЭЭДҮҮДЭД

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗАР**

Нийслэлийн засаг захиргааны IV байр,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160-0066
Утас:(976) 7575 7807, Факс: (976) 7575 7809
Цахим шуудан: contact@ub-procurement.mn
Цахим хаяг: www.ub-procurement.mn

2024.04.15 № 03/567
танай 2024.04.10 -ны № А15/24 -т

Тодруулга хүргүүлэх тухай

Тус газраас зарласан БШУЯ/20240101005/01/01 дугаартай Бага сургуулийн өргөтгөлийн барилга (Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 9 дүгээр хороо, 4 дүгээр сургууль) ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтад сонирхогч этгээдээс тодруулга ирүүлсэнтэй холбогдуулан захиалагчаас ирүүлсэн тодруулгын хариуг хавсралтаар хүргүүлж байна.

№	Тодруулга	Тодруулгын хариу
1	<p>Тендерийн баримт бичгийн ТШЗ 19.1 дэх хэсгийн шаардагдах ажиллах хүчний мэдээлэлд Ерөнхий инженер нь барилгын инженер бөгөөд мэргэшсэн болон түүнээс дээш зэрэгтэй байхаар шаардсан байна.</p> <p>“БА-2.1 Цутгамал болон угсармал төмөр бетон, мод ба арагт бүтээцэн барилгын угсралт, өргөтгөл, засвар шинэчлэлт, тохижилтын ажил болон түүнээс дээш” тусгай зөвшөөрөлтэй байхыг шаардсан байна.</p> <p>Манай байгууллагын зүгээс ТШЗ 19.1 дэх хэсэгт ерөнхий инженер нь мэргэшсэн болон түүнээс дээш зэрэгтэй байх шаардлагыг тендерт оролцогчдыг шударгаар өрсөлдөх боломжийг хязгаарласан байна гэж үзэж байна.</p>	<p>Тендер баримт бичгийн ТШЗ 19.1 дэх заалтын Ерөнхий инженер нь барилгын инженер бөгөөд мэргэшсэн инженер байж болно гэж залруулж байна.</p>

Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журмын 4.6 дахь хэсэгт “Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичгийн салшгүй хэсэг болох тодруулга, нэмэлт, өөрчлөлтийг тендер хүлээж авах эцсийн хугацаа хүртэл шалган нягталж, түүнд нийцүүлэн тендер бэлтгэнэ.” гэсний дагуу тендер ирүүлнэ үү.